



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай" 333 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09, 02/10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/531 дугаар захирамж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2022 оны дүрмийн 4.1.9, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголын Аялал жуулчлалын холбооноос санаачлан хэрэгжүүлж буй Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хот болон Япон улсын Токио, Шизүока, Осака хотуудад "Монголын Аялал жуулчлалын сурталчилгаа, танилцуулга" арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах төсвийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д зөвшөөрсүгэй.


3. Арга хэмжээ зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500165

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 21 өдрийн
1/19 дугаар тушаалын хавсралт



ГАДААД СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Арга хэмжээний заалны түрээс /БНСУ/	3	5 170 000 вон	5 170 000 вон
2	Арга хэмжээний заалны түрээс /Япон/	2	9 000 000 төгрөг 6 000 000 төгрөг	15 000 000 төгрөг
3	Сурталчилгааны сэтгүүл /Япон, Солонгос хэлээр/	2000	4500 төгрөг	9 000 000 төгрөг
4	Сэтгүүлийн орчуулга, эх бэлтгэл	2	3 200 000 төгрөг (орчуулгын зардал), 2 000 000 төгрөг (редакторлах зардал)	5 200 000 төгрөг
Нийт: 10 170 000 (арван сая нэг зуун дал) вон, 29 200 000 (хорин есөн сая хоёр зуун мянга) төгрөг Гадаад валютыг тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцно.				

-ooOoo-